

Дотоодод оршин сууж буй гадаадын иргэд(18с дээш нас) NOVAVAX(NVX) вакцинжуулалтын мэдээлэл.

Сүүлийн үед Корона19ийн халдвартай гадаадын иргэдийн тоо өндөр байгаа ба гадаадын иргэдийн Корона19ийн вакцинжуулалтын гүйцэтгэл нь ард иргэдтэй харьцуулахад бага байгаа учир Солонгос улсад аюулгүй амьдрахын тулд та бүхэн Корона19ийн вакцинаа заавал хамрагдана уу.

Дотоодод удаан хугацаагаар оршин сууж байгаа (90хоногоос дээш) 18с дээш насны гадаадын иргэд үнэ төлбөргүй Корона19ийн вакцинд хамрагдах боломжтой.

○ **NOVAVAX(NVX)** вакцин нь уургийн дахин нэгдэлийн уламжлалт аргаар үйлдвэрлэсэн вакцин, HPV, гепатитВ зэрэг олон янзын вакциныг ижил аргаар үйлдвэрлэсэн. MRNA вакцин(файзер, модерна) гэх мэт вакцины сөрөг нөлөөллөөс шалтгаалан 1,2,3дахь тунг хийлгэж амжаагүй байгаа 18с дээш насны дотоодод оршин сууж буй гадаадын иргэд **2р сарын 14өөс эхлэн NOVAVAX вакциныг хийлгэх боломжтой.**

- Эрүүл мэндийн даатгалтай эсэхээс үл хамааран Корона19 NOVAVAX вакцинжуулалт хийж буй эмнэлэгийн байгууллага болон эрүүл мэндийн төвд хандан хамрагдаж болно.

○ **Урьдчилсан захиалга · вакцинжуулалтын арга**

1) **Бүртгэлтэй гадаадын иргэд:** Гадаадын иргэний үнэмлэхний дугаарыг ашиглан онлайн болон утсаар урьчилан захиалга хийх боломжтой.

*Онлайн урьчилан захиалга: Корона19 вакцинжуулалтын урьдчилсан захиалгын системд (<https://ncvr.kdca.go.kr>)холбогдож өөрийгөө баталгаажуулсны дараа урьчилан захиалга хийнэ. (2.21~) → Эрүүл мэндийн төв болон итгэмжлэгдсэн эмнэлэгийн байгууллагат хандан вакцин хийлгэнэ (3.7.~)

** Утсаар урьчилан захиалга хийж тухайн өдөртөө тариулах: NOVAVAX(NVX) вакцинжуулалтын эрүүл мэндийн байгууллага болон эрүүл мэндийн төвөөс утсаар үлдэгдэл вакцин байгаа эсэхийг шалгасны дараа урьдчилан захиалга хийгээд (2.14.~) → тухайн өдөртөө очиж тариулах (2.14.~)

2) **Бүртгэлтгүй гадаадын иргэд(хууль бус оршин суугч хамрагдана):** Эрүүл мэндийн төвөөс түр хяналтын дугаар авч онлайн (орлогч урьчилан захиалга) болон утсаар урьчилан захиалга хийх боломжтой.

*Онлайн урьчилан захиалга(орлогч урьчилан захиалга): Корона19 вакцинжуулалтын урьдчилсан захиалгын системд (<https://ncvr.kdca.go.kr>) холбогдож орлогч өөрийгөө баталгаажуулсны дараа урьчилан захиалга хийнэ. (2.21~) → Эрүүл мэндийн төв болон итгэмжлэгдсэн эмнэлэгийн байгууллагат очиж тариулна.(3.7.~)

** Утсаар урьчилан захиалга хийж тухайн өдөртөө тариулах: NOVAVAX(NVX) вакциннийгэрүүл мэндийн байгууллага болон эрүүл мэндийн төвөөс утсаар үлдэгдэл вакцин байгаа эсэхийг шалгасны дараа урьдчилан захиалга хийнэ.(2.14.~) → тухайн өдөртөө очиж тариулна.(2.14.~)

*** Түр хяналтын дугаарыг хүчинтэй бичиг баримт байхгүй тохиолдолд утасны

дугаар,(өөрийн болон танилын) и-мэйл хаяг болон оршин суугаа хаяг аль нэг нь байхад авах боломжтой.

3) NOVAVAX вакцин (NVX) 3дахь вакцинжуулалт.

* NVX–NVX тарилгын дараа 3дахь тун: Онлайн урьчилан захиалга ба утсаар урьчилан захиалга хийж тухайн өдөртөө тариулах боломжтой.

** Бусад вакцин (модерна,mRNA, AZ, J) вакцин хийлгэсний дараа тухайн вакциныг хориглох, тарилгын хугацааг сунгах зэрэг шалтгаан байвал эмчийн дүгнэлтийн дагуу (NVX) 3дахь вакцинжуулалт: утсаар урьчилан захиалга хийж зөвхөн тухайн өдөртөө тариулах боломжтой.

※ ЖИЧ

- Хувийн мэдээллийг зөвхөн вакцинжуулалтын зорилгоор ашиглах бөгөөд мэдэгдэлийг чөлөөлөх тогтолцооны хүрээнд хууль бусаар оршин суух гэх мэт мэдээллийг цагаачлалын албанд дамжуулахгүйг мэдэгдэж байна.
- Дэлгэрэнгүй мэдээллийг БНСУын өвчний хяналт урьчилан сэргийлэх төв, Корона19 вакцинжуулалтын вэбсайтаас (<https://ncv.kdca.go.kr>) авна уу